



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/663

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.а, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гучин-Ус суманд баригдаж буй 250 хүний суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Нью констракшин" ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй гадна талбайн тохижилтын ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах 40.110.707 (дөчин сая нэг зуун арван мянга долоон зуун долоо) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101253

D:My Doc. Zahiramj. Zasag darga